

БАТЛАВ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

О.ЦОГТГЭРЭЛ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах дараах үндэслэл байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот тогтоол гарснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог сонгох асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байгааг эцэслэн шийдвэрлэсэн.

1.2.Практик үндэслэл

Өнгөрсөн найман удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн дийлэнх олонхыг дан мажоритар системээр явуулсан. 2000 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан МАХН Улсын Их Хурлын 76 суудлын 95 хувь буюу 72 суудлыг авсан бол 24.1 буюу нийт сонгогчдын дөрөвний нэгийн саналыг авсан Ардчилсан нам нэг суудал авч байжээ.

2016 онд нийт сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН нь УИХ-д 65 суудал буюу нийт суудлын 85.5 хувийг, харин 34.2 хувийн санал авсан Ардчилсан нам 9 буюу нийт суудлын 12 хувийг тус тус авч байв.

Энэ удаагийн парламентыг бүрдүүлсэн 2020 оны Улсын Их хурлын ээлжит сонгуульд сонгогчдын 45 хувийн санал авсан МАН нийт суудлын 82 хувийг авсан бол нийт сонгогчдын 24 хувь буюу дөрвөн сонгогч тутмын нэгийн саналыг авсан АН 11 суудал буюу нийт суудлын 14 хувийг авчээ.

Энэ мэтээр сонгуулийн үр дүн савалж, иргэд сонгогчдын санал гээгддэг муу жишиг мажоритар тогтолцоонд ихээр тохиолдож байна. Нийт сонгогчдын 50-аас доош хувийн санал авсан улс төрийн хүчин хууль тогтоох байгууллагад үнэмлэхүй суудал авч, засгийн бүх эрхийг авч байгаа нь иргэд сонгогчдын хүсэл зориг, шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Сонгуулийн тогтолцооны энэ гажуудлыг засахын тулд сонгуулийн холимог тогтолцоог хуульчилж, төрийн эрх мэдлийг ард түмэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Одоогийн мөрдөгдөж буй Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар аль нэг хүйсийн доод хэмжээ 20 хувьтай байгаа боловч сонгуулийн үр дүнгээр 20 хүрэхгүй

гишүүд сонгогддог практик бий. Ийм учраас хүйсийн квот дээр үр дүнтэй уялдах схемийг бүрдүүлэх шаардлага байна.

Мөн сонгуулийг шударгаар явуулах нөхцлийг бүрдүүлэх нь сонгуулийн тогтолцоог зөв сонгохоос дутуугүй ач холбогдолтой. Иймд энэхүү төслөөр сонгуулийг шударгаар зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төслөөр дараах нэмэлт өөрчлөлтийг оруулахаар тусгав. Үүнд:

- Сонгуулийн тогтолцоог холимог байхаар хуульчилж, тойргоос 48, жагсаалтаар 28 хүн сонгохоор зааж өгөв.
- **Жагсаалт хуваарилахад улс нэг гэдэг зарчим барьсан.**
- 48 мандатыг тойрог хуваах зарчмаар хуульд тусгаж өгсөн, өмнөх 12.2 дугаар зүйлийг энэ зарчимд нийцүүлж, өөрчлөн найруулав. Тойрогт хамгийн олон санал авсан нэр дэвшигч явах ба нийт сонгогчийн 28 хувиас доош санал авсан тохиолдолд дахин санал хураалт явагдана.
- Нэр дэвшүүлэх зарчим хэвээр байхаар оруулсан.
- Тойрогт болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.
- Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
- Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.
- Жагсаалт нээлттэй байна.
- Жагсаалтаар нэр дэвшсэн нам, эвслийн сонгуулийн дүн гаргах, суудал хуваарилах зарчмыг нам эвсэл 3 хувь байхаар оруулав. Мөн тойрогт суудал авсан байх шалгуурыг оруулна.
- Тойргийн хорооны дарга, бүрэлдэхүүнийг гэрчилгээтэй төрийн захиргааны ба үйлчилгээний албан тушаалтан байхаар оруулсан.
- Сонгуульд санал өгсөн иргэн бэхэн тэмдэглэгээ заавал хийлгэнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн Албаны тухай хууль, Төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.